| 131001      | Улсын төсвөөс санхүүжих                                         | 29,653,467,000.00        | 27,045,335,992.74        | 2,608,131,007.26        | 91.2         |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл                |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------|------------|--------------------------|
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                                                                   | -          | <b>12,567,028,180.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                                                       | -          | <b>12,567,028,180.00</b> |
| <b>212</b>  | <b>ТАТААС</b>                                                                                              | -          | <b>12,567,028,180.00</b> |
| <b>2121</b> | <b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>                                                              | -          | -                        |
| 212101      | Төрийн өмчит байгууллагад олгох татаас                                                                     | -          | -                        |
| <b>2122</b> | <b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>                                                           | -          | <b>12,567,028,180.00</b> |
| 212201      | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас                                                                  | -          | 12,567,028,180.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                      | -          | <b>12,567,028,180.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                         | -          | <b>12,567,028,180.00</b> |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | -          | 12,567,028,180.00        |

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Насантогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд балансын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын аудитор Г.Түвшинзаяа, С.Бат-эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн в/298 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрчим хүчний салбарын аюулгүй, найдвартай ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах;
- Эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болгох, бүс нутгийн шугам сүлжээ байгуулах;
- Эрчим хүчний хангамжийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах;
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
- Эрчим хүчний эх үүсвэрүүдийн түлшний баланс гаргах замаар нүүрсний уурхайнуудын хүчин чадлыг өргөжүүлэх;
- Эрчим хүчний нүүрсний болон шинэ, хийн түлшний технологийг хөгжүүлэх, инновацийг дэмжих;
- Салбарын эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхийг сайжруулах, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;
- Салбарын удирдлага болон тогтолцоог боловсронгуй болгох, тус салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын өрсөлдөх чадавхийг дээшлүүлэх;
- Эрчим хүч, түлш (эрчим хүчний нүүрс)-ний салбарт шинжлэх ухаан, технологи, эрчим хүчний балансын судалгаа, стандарт, норм, нормативын баримт бичиг, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийж, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Эрчим хүчний яам нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар дүгнэлт зөвлөмж хүргүүлж, хуулийн хэрэгжилтэнд тогтмол хяналт тавин зөрчил арилгах дараах арга хэмжээг аваагүй байна.

Эрчим хүчний яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 39,966,905.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 399,669.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрчим хүчний яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,265,393.1 мянган төгрөгөөр буюу 28.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                          | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт           |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Б                                                 | 1                  | 2                  | 3=2-1              |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                  | -                  | -                  |
| Авлага                                            | 349.1              | 755.6              | 406.5              |
| Урьдчилгаа                                        | -                  | -                  | -                  |
| Бараа материал                                    | 22,346.4           | 37,172.7           | 14,826.3           |
| Үндсэн хөрөнгө                                    | 4,453,529.9        | 5,703,690.2        | 1,250,160.3        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>4,476,225.4</b> | <b>5,741,618.5</b> | <b>1,265,393.1</b> |
| Өр төлбөр                                         | 285.3              | 1,748.7            | 1,463.4            |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/          | 4,475,940.1        | 5,739,869.8        | 1,263,929.7        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>4,476,225.4</b> | <b>5,741,618.5</b> | <b>1,265,393.1</b> |

Авлага дансны үлдэгдэл 755.6 мянган төгрөг болж 406.5 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагчидтай холбогдсон авлагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 37,172.7 мянган төгрөг болж 14,826.3 мянган төгрөгөөр өссөн нь Диспетчерийн үндэсний төв ХХК-иас бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/1988 дугаартай албан бичгээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй эргэлтийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,703,690.2 мянган төгрөг болж 1,250,160.3 мянган төгрөгөөр өссөн нь тус байгууллагын барилгын их засварын зардлыг ТӨБЗГ-ын 2020 оны 751 дүгээр тогтоолын дагуу капиталжуулж бүртгэснээс голлон шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө урсгал төсвөөс бэлтгэсэн 149,989.2 мянга, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Диспетчерийн үндэсний төв ХХК, Улаанбаатар-Мандалговь ЦДАШДСБ төслөөс үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,302,999.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө Эрчим хүчний хөгжлийн төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнд үнэ төлбөргүй шилжүүлсэн 16,822.4 мянга, ТӨБЗГ-ын 2020 оны а/1/949 тоот албан бичгийн дагуу 26,928.2 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө 4,800.0 мянган төгрөгөөр буурсан нь ашиглалтгүй албан хэрэг хөтлөлтийн архивын программыг ТӨБЗГ-ын 2020 оны А-1/949 дугаартай актлах зөвшөөрлийн албан бичгийн дагуу хасалт хийснээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,748.7 мянган төгрөг болж 1,463.4 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүний орлогын албан татварын өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,739,869.8 мянган төгрөг болж 1,263,929.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүй орлого хүлээн авснаас шалтгаалсан байна.

Эрчим хүчний яамны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 9,517,603.5 мянган төгрөгөөр буюу 30 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан татварын бус орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ба урсгал үйл ажиллагааны санхүүжилт буюу эрчим хүчний үйлдвэр, компанид олгох дизелийн станцын алдагдлын татаас, цахилгаан дамжуулах системийн алдагдлын татаас, дулааны станцын алдагдлын татаасууд байна.

Нийт зардал өмнөх оноос 8,092,469.0 мянган төгрөгөөр буюу 20.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалингийн зардал, төрийн өмчит байгууллагад олгох татаасын зардлууд байна. Энэ нь төрийн албан хаагчийн цалингийн хэмжээ нэмэгдсэн, эрчим хүчний үйлдвэр, компанид олгох дизелийн станцын алдагдлын татаас, цахилгаан дамжуулах системийн алдагдлын татаас, дулааны станцын алдагдлын татаасын зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 67,352,515.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 67,352,515.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,699,048.1 мянган төгрөгөөр бууруулж 29,653,467.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн саналыг бууруулж баталсан шалтгаан нь "Гэр хорооллын айл өрхүүдэд олгох цахилгааны хөнгөлөлт"-д олгох татаасыг 2020 онд Эрчим хүчний сайдын төсвийн багцад төлөвлөсөн саналыг Сангийн яам хүлээн аваагүй байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 29,653,467.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 27,358,895.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 27,045,336.0 мянган төгрөгийг зарцуулж 313,559.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 27,045,336.0 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь улсын төсвөөс 2,294,571.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсоноос шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам” батлах тухай 199 дугаар тогтоолын дагуу шилжүүлсэн нийт 12,567,028.2 мянган төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтээр орсон байна.

Үүнийг эрчим хүчний компаниудад 12,567,028 мянган төгрөгийн татаасыг шилжүүлсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 156 мэдээллээс 136 мэдээллийг хугацаанд нь, а 2 мэдээлэл оруулах хугацаа болоогүй, 11 мэдээллийг хугацаа хоцроосон, 364,096.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын хэсгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 22,166.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаягыг мэдээллээгүй;
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт Төсөв захирагчийн төсвийн зарцуулалтын Б/78 дугаартай 33,223.6 мянган төгрөг, Б/130 дугаартай 32,875.7 мянган төгрөг, Б/215 дугаартай 35,148.6 мянган төгрөг, Б/283 дугаартай 240,682.2 мянган төгрөгийн тушаалуудыг байршуулаагүй.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,356,795.3 мянган төгрөгийн 7 зөвлөмжийн хэрэгжилт 89 хувьтай байна.

Хэрэгжүүлээгүй 2,323,808.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилтэнд дараах нөхцөл байдал үүссэн байна. Үүнд:

- “Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байрлалтай хуваарилах байгууламж №7-ийн хүчин чадлын нэмэгдүүлж өргөтгөх барилга угсралтын ажил”-ын (1,481,600.0 мянган төгрөг) барилга, байгууламжийг ашиглалтад оруулах техникийн комисс ажиллаж 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174/2011 дугаартай акт үйлдэн хүлээн авсан. Гэвч тус барилга, байгууламж нь газрын маргаантай Эрчим хүчний яамнаас шалтгаалахгүй ажил тул хэрэгжих боломжгүй байна.
- Булган аймгийн дулааны станцын байгууламжийн (842,208.2 мянган төгрөг) барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 41/2019 дугаартай акт үйлдэн улсын комисс хүлээн авсан ч ТӨБЗГ-с өмч эзэмшлийн хувь нь тогтоогдоогүйгээс ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэхээр болов.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 665,218.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 34,776.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 613,171.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 17,271.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

## **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд 34,776.1 мянган төгрөгийн цалин, НДШ-ийн, тээврийн хэрэгслийн татвар хураамжийн зардлын дансны ангилал буруу бүртгэсэн байгааг залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 613,218.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн Б/282 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 3 сар хүртэлх хугацааны үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 200,829.1 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулж олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” заасантай тус тус нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд нийт 48,246.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Үүнд: НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 25,451.5 мянган, цалингийн зардлаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 18,422.6 мянган, тээврийн хэрэгслийн татварын зардлаас даатгалын үйлчилгээний зардалд 3,172.0 мянган, улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардлаас бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 1,200.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай заавар”, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтийн төсөл арга хэмжээнд бий болсон Булган аймгийн дулааны станцын байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 41/2019 дугаартай акт үйлдэн хүлээн авсан барилга байгууламжийг ТӨБЗГ-аар өмч эзэмшлийн хувь тогтоогдоогүйгээс ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам”-ын 4.1.2-т “ батлагдсан эх үүсвэрээ бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, бүргэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ” заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 156 мэдээллээс 364,096.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Шилэн дансны зарчим”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” 6.4.4-т “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифийн хөнгөлөлтийг үндэслэн 2017 оноос гэр хорооллын айл өрхүүдэд хөнгөлөлт үзүүлж, санхүүжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөрөөс санхүүжүүлж ирсэн байна. Орчны бохирдол бууруулах үндэсний хорооноос уг арга хэмжээний төсвийг жил бүр баталж, баталсан төсвийн хүрээнд санхүүжилтийг олгож ирсэн боловч гүйцэтгэлээр зардал жил бүр хэтэрч 2020 оны жилийн эцсийн байдлаар 14 эрчим хүчний төрийн өмчит компаниудад өгөх хуримтлагдсан өр төлбөр бий болсон ба уг авлага, төлбөрийг барагдуулах талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, арга хэмжээ аваагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 17,271.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

- Тус яамны эзэмшилд 372,230.8 дансны үнэтэй 7 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн эвдрэл гэмтэл ихтэй цаашид ашиглах боломжгүй болсон 274,798.5 мянган төгрөгийн дансны үнэтэй тээврийн хэрэгсэл байна. Иймд цаашид ашиглагдахгүй болсон тээврийн хэрэгслийг актлуулах саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалт газарт хүргүүлж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1.Балансын данстай холбоотой асуудал*

###### 1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд 15,522.5 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэж, тайлагнасан байна. Энэ нь УСНББОУС-17-д "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө; а/ бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний үйлдвэрлэлт буюу нийлүүлэлтэд, бусдад түрээслүүлэхээр эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж буй байгууллагын эзэмшилд байгаа ба б) нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэсэн заалттай нийцээгүй ба Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 1.2. Эрсдэл:

Элэгдлийн зардал нэмэгдэж, тайлант үеийн үр дүн бүрэн илэрхийлэгдэхгүй байх

###### 1.3. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байгаа бараа материалын шинж чанартай эргэлтийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэх

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

##### *2. Балансын данстай холбоотой асуудал*

###### 2.1. Илрүүлэлт:

Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 1.748.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заасантай нийцэхгүй, Үнэн зөв айл батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### 2.2. Эрсдэл:

Тухайн жилийн төсвийг үр ашигтай зарцуулж чадахгүй байх

###### 2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тайлант жилд өр, авлага үүсгэхгүй байж төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах

###### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:

2021

Аудитын нэр:

*Эрчим хүчний яамны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*

Аудитын код:

САГ-2021/80/СТА-ТШЗ

Шалгагдсан байгвүллагын нэр:

**Эрчим хүчний яам**

Мянган төгрөг

| №          | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | Мөнгөн дүн       | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны                      |                                          |
|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|---------------------------------------|------------------------------------------------------------------------|------------------------------------------|
|            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |                  | Нэр                                   | Албан тушаал                                                           | Овог нэр                                 |
|            | 1                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    | 2                | 3                                     | 4                                                                      | 5                                        |
| 1          | Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн Б/282 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 3 сар хүртэлх хугацааны үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 200,829.1 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулж олгосон байна                                                                                                                                                                                                                                                                | 200,829.1        | Албан шаардлага                       | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга                 | Б.Насантогтох Ж.Жанарбаатар              |
| 2          | Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд нийт 48,246.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                       | 48,246.2         | Албан шаардлага                       | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга                 | Б.Насантогтох Ж.Жанарбаатар              |
| 3          | Улсын төсвийн хөрөнгө оруулалтийн төсөл арга хэмжээнд бий болсон Булган аймгийн дулааны станцын байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 41/2019 дугаартай акт үйлдэн хүлээн авсан барилга байгууламжийг ТӨБЗГ-аар өмч эзэмшлийн хувь тогтоогдоогүйгээс ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна                                                                                                                                               | -                | Албан шаардлага                       | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга    | Б.Насантогтох А.Энхбат                   |
| 4          | Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 156 мэдээллээс 364,096.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | 364,096.1        | Албан шаардлага                       | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга    | Б.Насантогтох А.Энхбат                   |
| 5          | Орчны бохирдол бууруулах үндэсний хорооноос “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх” арга хэмжээний төсвийг жил бүр баталж, баталсан төсвийн хүрээнд санхүүжилтийг олгож ирсэн боловч гүйцэтгэлээр зардал жил бүр хэтэрч 2020 оны жилийн эцсийн байдлаар 14 эрчим хүчний төрийн өмчит компаниудад өгөх хуримтлагдсан өр төлбөр бий болсон ба уг авлага, төлбөрийг барагдуулах талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, арга хэмжээ аваагүй байна | -                | Албан шаардлага                       | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга    | Б.Насантогтох А.Энхбат                   |
| 6          | Үндсэн хөрөнгийн дансанд 15,522.5 мянган төгрөгийн бараа материалын шинж чанартай хөрөнгийг бүртгэж, тайлагнасан байна                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 15,522.5         | Зөвлөмж өгөх                          | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга    | Б.Насантогтох А.Энхбат                   |
| 7          | Төсвийг зохистой удирдаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд 1.748.7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсан байгаа нь                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 1,748.7          | Зөвлөмж өгөх                          | Төрийн нарийн бичгийн дарга, Санхүүгийн хэлтсийн дарга, Нягтлан бодогч | Б.Насантогтох Ж.Жанарбаатар Л.Оюундэлгэр |
| <b>ДҮН</b> |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | <b>630,442.6</b> |                                       |                                                                        |                                          |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 68/А0170077  
САТ-2021/80/СТА ТМЗ  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн Б/282 дугаар тушаалаар нийт ажилтнуудад 3 сар хүртэлх хугацааны үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 200,829.1 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", мөн тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан "төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагч нь албан хаагчдын цалин хөлс, урамшуулал олгохтой холбоотой тушаал шийдвэр гаргахдаа Засгийн газраас тогтоосон хууль, журмыг мөрдөн ажиллаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Г.ТҮВШИНЗАЯА

С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар38.Docx

001081146



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 69/АД/70077

Улаанбаатар хот

САГ- 2021/80/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт зохицуулалт хийх зөвшөөрөлгүйгээр зардлын эдийн засгийн ангиллын бүлэг хооронд нийт 48,246.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Үүнд: НДШ-ийн зардлаас цалингийн зардалд 25,451.5 мянган, цалингийн зардлаас тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 18,422.6 мянган, тээврийн хэрэгслийн татварын зардлаас даатгалын үйлчилгээний зардалд 3,172.0 мянган, улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардлаас бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 1,200.0 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан "Эдийн засгийн ангилал батлах тухай заавар", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6 дахь "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тухай хууль тогтоомж болон холбогдох журам, зааврыг зөрчиж, Төсвийн эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Жанарбаатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА  
С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 67/А0170077

Улаанбаатар хот

СДХ - 2021/80/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд нийт 156 мэдээллээс 364,096.1 мянган төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Шилэн дансны зарчим", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, емч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга А.Энхбат нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР

*(Handwritten signatures and stamps)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА  
С.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264210

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_ShaardInga\2021\0225auditin 2-R Газар41.Docx

001081158





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 66/АД170077  
САН-2021/80/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд бий болсон барилга, байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссын актаар хүлээн авсан барилга байгууламжийг ТӨБЗГ-аар өмч эзэмшлийн хувь тогтоогдоогүйгээс ашиглагч байгууллагуудад шилжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах шилжүүлэх журам"-ын 4.1.2-т "батлагдсан эх үүсвэрээ бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж, бүргэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТӨБЗГ-т хандан өмч эзэмшлийн хувь тогтоолгож, ашиглагч байгууллагад хөрөнгийг шилжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга А.Энхбат нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ТҮВШИНЗАЯА  
С.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 86/АД170077  
САГ-2021/80/СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрчим хүчний яамны 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан тарифын хөнгөлөлтийг үндэслэн 2017 оноос гэр хорооллын айл өрхүүдэд хөнгөлөлт үзүүлж, санхүүжилтийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний хөтөлбөрөөс санхүүжүүлж ирсэн байна. Орчны бохирдол бууруулах үндэсний хорооноос уг арга хэмжээний төсвийг жил бүр баталж, баталсан төсвийн хүрээнд санхүүжилтийг олгож ирсэн боловч гүйцэтгэлээр зардал жил бүр хэтэрч 2020 оны жилийн эцсийн байдлаар 14 эрчим хүчний төрийн өмчит компаниудад өгөх хуримтлагдсан өр төлбөр бий болсон ба уг авлага, төлбөрийг барагдуулах талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.3-т “бүх өр төлбөр”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох,

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар80.Docx

давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Эрчим хүчний төрийн өмчит компаниудын авлагыг барагдуулах талаар Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран ажиллаж, татаасын санхүүжилтийг бодитой олгох, шийдвэрлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга А.Энхбат нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Г.ТҮВШИНЗАЯА

С.БАТ-ЭРДЭНЭ

